

**ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 02 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

**1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:**

XVII жарны Шороон гахай жилийн сар шинийн баярыг угтаж аймгийн ИТХ-ын даргын мэндчилгээ, 2018 онд аймгийн ИТХ, Тэргүүлэгчид, ажлын албанаас хийсэн ажлын тайланг Завхан сонинд нийтлүүлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээллээ.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хуралдаж 2018 онд хийсэн ажлын гүйцэтгэлийг хэлэлцэж үр дүнтэй сайн хэрэгжсэн гэж дүгнэн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлаас архи худалдан борлуулдаг цэг тусгай зөвшөөрөлтэй дэлгүүрүүдэд архи худалдан борлуулахыг хориглосон өдрөөр лангууны өмнө хөшиг татах /архины хор хөнөөлийг иргэн, үйлчлүүлэгч нарт сурталчлан таниулж/ урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд салбар зөвлөлөөс зөвлөмж гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын хурлыг хийж 2019 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Асгат сумын иргэн Г.Ренчинмядагын ирүүлсэн өргөдөл, холбогдох материалыг бүрдүүлж Монгол улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүлж нөхөн олговрын нэг сая төгрөгийг Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн дагуу шийдвэрлэж иргэнд олгосон.

Дэлхийн зөн Олон улсын байгууллага, оёдолчидтой хамтран аймгийн зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд европ хувцасны ерөнхий эсгүүрийн сургалтыг 02 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд аймгийн ИТХ-ын Иргэний танхимд зохион байгууллаа.

Сургалтыг оёдолчин С.Алтанцэцэг удирдаж зорилтот бүлгийн 10 эмэгтэйд эсгүүрийн сургалтыг явууллаа.

Орчин үед дэлхийн улс үндэсний хувцасны хэв маягаа хадгалах боловч европ маягийн хийцтэй хувцас нийтлэг өмсөж, эсгэлт, оёдлын нэг технологийг хэрэглэх болсон байна.

Сургалтаар оролцогчид Европ хувцсыг зохион бүтээлтийн хялбаршуулсан аргаар эсгэж, технологийн дагуу оёх арга мөн европ хувцасны ерөнхий эсгүүрээс хэрхэн өөр бусад төрлийн хувцасны эсгүүр гаргаж авах аргуудад суралцлаа.

Мөн энэ сарын 27-ны өдөр “Ус” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг аймгийн ИТХ-ын хүнс, хөдөө аж ахуй, ногоон хөгжлийн бодлогын хорооны Төлөөлөгчдөөр хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэний нийгмийн байгууллагын төлөөллүүдээс санал авч, саналыг нэгтгэж төслийн нэгжид хүргүүллээ.

## **1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл**

Завхан аймаг орон нутагтаа баялаг бүтээх, баялаг бүтээгчдээ дэмжих, тэдний бараа бүтээгдэхүүнийг зах зээлж боруулахад нь хамтран ажиллах, ажлын байрыг нэмэгдүүлж ард иргэдээ ажилтай орлоготой болгоход ихээхэн анхаарч ажиллаж байгаа. Тиймдээ ч хэрэглэгч аймгаас үйлдвэрлэгч аймагт шилжих зорилгоо биелүүлэхийн тулд алхам алхмаар урагшилж, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо жилээс жилд нэмэгдсээр байна. 2019 он гарсаар орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийнхээ бараа бүтээгдэхүүнээр 3 удаагийн томоохон үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 400 гаруй сая төгрөгийн борлуулалт хийгээд байгаа юм. Тэгвэл шороон гахай жил гарсаар хамгийн түрүүнд хэрэглэгч аймгаас үйлдвэрлэгч аймагт шилжих зорилтоо хэрхэн богино хугацаанд, илүү үр дүнтэй хэрэгжүүлж, нутгийнхаа хөгжлийг хурдасгах талаар Завханчууд зөвлөлдөх зорилгоор нэгдсэн золголтоо зохион байгууллаа. Нутгаа гэсэн сэтгэлтэй мянга мянган иргэд монгол бөхийн өргөөнд дүүрэн цугларч амар мэндээ мэдэхээс гадна төрөлх нутгийнхаа хөгжлийн гарц шийдлийг ярилцсан үр дүнтэй уулзалт болсон юм. 24 сумын төлөөлөл, удирдлагууд УБ хот дахь нутгийн түмэндээ хүндэтгэл үзүүлж, нутгийнхаа хөгжилд ташуур өгөх тэдний санал бодлыг сонсож, хөгжлийнхөө тухай ярилцлаа. Завхан аймгийн УБ хот дахь Нутгийн зөвлөл, Завхан аймгийн ИТХ, Засаг дарга, түүний тамгын газар хамтран зохион байгуулсан энэхүү нэгдсэн золголт, уулзалтыг зорьж үе үеийн аймгийн удирдлагууд, боловсрол, соёл, шинжлэх, ухаан, урлаг, спортын гээд салбар салбарын алдартнууд хүрэлцэн ирсэн байлаа.

Залуу халуун насаа төрөлх нутгийнхаа хөгжил цэцэглэлийн төлөө зориулсан 90-ээс дээш настай ахмад буурлууддаа ч мөн энэ үеэр хүндэтгэл үзүүлж үнэтэй сургаалийг нь сонссон юм. Завхан аймгийн УБ хот дахь Нутгийн зөвлөлтэйгөө хамтран сум бүрт тухайн нутаг орныхоо онцлогт тохирсон жижиг үйлдвэрүүд байгуулах гэрээг 4-р сард үзэглэхээр төлөвлөөд байна. Мөн Улаанбаатар хотод

ажиллаж амьдарч байгаа Завхан сэтгэлтэй хүн бүрийг хөгжлийн төлөө нэгэн зорилгын дор хамтран ажиллахыг уриалж байгаа юм.

Энэ үеэр Завхан аймаг шороон нохой жилийн онцлох хүнээрээ Болор цом-2018 наадмын тэргүүн байрын шагналт, яруу найрагч Базарсадын Баттулгыг тодрууллаа. Завханчууд хандив цуглуулж болор цомын эзэндээ 2 өрөө байр авч өгсөн бол байрных нь төлбөрт орон нутгаасаа 5 сая төгрөг гардуулсан юм. Олон хутагт хувилгаад мэндэлсэн, оюуны их энергийн төв гэгддэг Завхан нутгийнхаа хөгжил цэцэглэлт, ард түмнийхээ амар амгалан, эрүүл энх, сайн сайхан байхын тухайд Жалханз хутагт Данзанчойживанчүг тэргүүтэй 108 лам засал, ном айлтгаж, Завхан нутгийн урлаг соёлын алдартнуудын тоглолт болж, Завхан аймгийн харьяат хүчит 64 бөх барилдлаа. Барилдаанд Монгол улсын гарьд Б.Гончигдамба түрүүлж, монгол улсын харцага Бэгзсүрэн үзүүрлэлээ. Гончигдамба гарьд түрүү бөхийн бай болох телевизээрээ болор цомын эзэн яруу найрагч Баттулгыг мялааж нутгийн түмнээ баярлууллаа. Ийнхүү оюуны их энергийн төв, Оюунлаг Завханчууд нутгийнхаа хөгжлийн төлөө чуулж, сар шинийн нэгдсэн золголтоо Монгол бөхийн өргөө дүүрэн, өргөн дэлгэр зохион байгууллаа.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

**2.1.Татвар төлөлтийн байдал:** Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 132.1 хувийн биелэлттэй, 626.6 сая төгрөгийн орлого оруулсаны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 44.7 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.6 хувь, аж ахуйн нэгж байгууллагын албан татвар 0.9 хувь, хүн амын орлогын албан татвар 28.0 бусад нэр төрөл 22.8 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 93.4 хувь буюу 585.7 сая төгрөгийг орон нутгийн орлого, 6.6 хувь буюу 40.9 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Монгол банкны мэдээгээр эхний 1 сард 1 тэрбум 653.4 сая төгрөг гүйлгээнд гарч, иргэдийн мөнгөн хадгаламжинд 68.1 мянган иргэний 89.9 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 19.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аймгийн дүнгээр 10.5 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 1.8 тэрбум төгрөгөөр буурсан байна. Зээлийн сарын хүүг арилжааны банкуудаар авч үзвэл дунджаар ХААН банк 1.30 хувь, Хас банк 0.58-2.0 хувь, Төрийн банк 1.8 хувь, Капитал банк 1.5 хувь байна.

### **Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:**

**3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа:** 2019 оны 02 дугаар сарын байдлаар Засаг даргын үйл ажиллагааны 20, Боловсон хүчний 2 захирамж гарсан байна. Үүнд:

Комисс томилох тухай, Хөрөнгө гаргах тухай, Ажлын хэсэг байгуулах тухай, Захирамж хүчингүй болгох тухай, Үнэлгээний хороо байгуулах тухай, Иргэнд газар өмчлүүлэх тухай, Эрх сэргээх тухай, Зөрчил арилгуулж захирамж хүчингүй болгох тухай, Ажлаас чөлөөлөх тухай, Ажилд томилох тухай, газар эзэмших эрх шилжүүлэх тухай, эзэмших, өмчлөх эрх олгох тухай, Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай, Урамшуулал олгох тухай, Эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай гэх мэт захирамж гаргалаа.

2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хурал болж аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга У.Батдаваа оролцоо. Энэхүү хуралдаанаар 2019 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг баталсан байна.

Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хот тохижилт үйлчилгээний албаны албан хаагчдад Зөрчлийн тухай хууль болон Замын хөдөлгөөний шинэчилсэн дүрмээр сургалт зохион байгууллаа.

**3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл:** Аймгийн хэмжээгээр эхний 1 сард 23 гэмт хэрэг гарсаны 38.8 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 33.3 хувь нь бусдын өмчийн өмчлөлийн эсрэг гэмт хэрэг, 27.9 хувийг бусад төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Эхний 1 сард 395 зөрчил илрүүлж, 28 хүн эрүүлжигдэн, 2 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 178, эрүүлжигдсэн хүн 39, баривчлагдсан хүн 8-аар тус тус буурсан байна.

**3.3. Архивын ажлын мэдээлэл:** Ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 1 хөмрөг, 1 данс, 10 хадгаламжийн нэгжийн 351 хуудас баримтыг сканердаж, 1 хөмрөг 1 дансны 10 хадгаламжийн нэгж, 351 хуудас баримтыг photoshop програмд засварлалаа.

9 хөмрөгийн удирдлагын баримт бичгийг баримтын түвшинд тодорхойлон бичих, тоо бүртгэлийн програмд оруулах ажлын хүрээнд 9647 хуудас баримтаас 12777 заалт, 29147 хүний нэр, 9 байгууллагын нэр, 372 газар зүйн нэр программд шивж 166 PDF файл үүсгэн эх баримтыг холболоо.

154 иргэн, 9 байгууллагын хүсэлтийг хүлээн авч 438 баримт шүүж, 123 хуулбар, 82 лавлагаа 53 тодорхойлолт олгож төрийн үйлчилгээ үзүүллээ. Тоо бүртгэлийн нэгдсэн программд 38 байгууллагын мэдээг шивж оруулсан.

Хөмрөг үүсгэгч 51 байгууллагын судалгаа гаргаж, 2019 онд Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх хуваарь гаргаж баталсан, мөн 2019 онд цахим мэдээллийн санд оруулах хөмрөгийн судалгаа хийж, Архивын тасгийн ажилтнуудын 2019 онд

мэдээллийн технологит шилжүүлэх ажлын төлөвлөгөө гарган баталж мөрдүүлэн ажиллаж байна.

Боловсрол соёл урлагийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэгийн ажлын байранд төрийн 46 албан хаагчид “ Албан хэрэг хөтлөлт, албан бичгийн стандарт, Архивын баримт бүрдүүлэлт, Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулж мөрдөх” чиглэлээр сургалт хийсэн.

**3.4. Онцгой байдал: Аймгийн онцгой комиссын чиглэлээр:** аймгийн Онцгой комиссын хурлыг 3 удаа зохион байгуулж Засаг даргын захирамж 1, Засаг даргын албан бичиг 2 тус тус гарган холбогдох байгууллага, сум, албан тушаалтнуудад хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавин үр дүнг тооцон ажиллаж байна. Онцгой комиссын хурлаар дараах асуудлыг шийдвэрлэж ажилласан. Үүнд:

Аймгийн зарим сумдад өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан аймгийн **Онцгой комиссын 02 дугаар хурлыг** 2019 оны 02 дугаар сарын 11-нд хуралдуулж Аймгийн аюулгүй нөөцийн өвс тэжээлээс Тосонцэнгэл суманд 600 уут хивэг, Их- Уул суманд 400 уут хивэг, Идэр, Тэлмэн суманд 200 уут хивэг, 300 боодол өвсийг үнэгүй, тэжээлийн 50 хувийн хямдралтай үнээр 1 уут тэжээл 25 кг 710 \ долоо мянга нэг зуу\ олгохоор шийдвэрлэсэн.

Мөн 03 дугаар хуралдааныг 2019 оны 02 дугаар сарын 15-ний 08 цагт аймгийн эрүүл мэндийн газарт Улиастай сумын 6 дугаар цэцэрлэгийн Н.Билгүүн /1 нас 11 сартай, эрэгтэй/ 2019 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн 17:00 цагт цэцэрлэгээсээ тараад өндөр халуурсан зовууртай аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт үзүүлж 2019.02.14-ний өдрийн 10:45 цагт биеийн байдал хүндэрч менингит, менингококкцемиа хавсарсан давшингуй явцтай халдвар хордлогын шок оноштойгоор 19:45 цагт нас барсан. 15-ний өглөөний 08 цагт Аймгийн Онцгой комиссыг хуралдуулж Улиастай сумын 1 болон 6 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаагаар хаах, аймгийн хэмжээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагааг 14 хоногийн хугацаатай хориглох, менингоккт болон томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, сэрэмжлүүлэг мэдээг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан ард иргэдэд хүргэх шийдвэрийг гаргуулан хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

**04 дүгээр хуралдааныг** 2019 оны 02 дугаар сарын 18-ний өдөр Мөрөн Булганы чиглэлийн төвийн системийн Цахилгаан дамжуулах шугам сүлжээнд 19:30 минутанд эвдрэл гарсаны улмаас Завхан аймгийн бүх чиглэл 0 зогсолт хийсэн. 22:30 минутанд Аймгийн Онцгой комиссыг хуралдуулж Шуурхай арга хэмжээ авсаны үндсэн дээр Тайширын Усан цахилгаан станцаас 1 мвт Богдын голын УЦС-с дизель станцаас 350

квт нийт 1600 квт-ийн цахилгаан авч Улиастай сумын 7 чиглэлээс 6 чиглэлийг цахилгаанаар хэвийн ханган ажилласан.

Алдархаан, Цагаанчулуут, Шилүүстэй, Улиастай сумыг Тайширын усан цахилгаан станцаас, Тосонцэнгэл, Түдэвтэй, Нөмрөг сумууд Дизель станцаар, бусад нам даралтын зуухтай сумдад Онцгой комиссоос хариуцлагатай жижүүр гаргах, галын аюулаас урьдчилан сэргийлэх, цахилгааны эх үүсвэр гаргах нөөц мотор, дизель түлшний нөөц бүрдүүлэх талаар үүрэг чиглэлийг өгч ажилласан.

Энэ сард хяналт шалгалтын график төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Шадар сайдын баталсан удирдамжийн хүрээнд Улиастай болон Тосонцэнгэл сумдад үйл ажиллагаа эрхэлж буй хүн ам олноор цуглардаг худалдаа олон нийтийн 13 байгууллагад, **төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулсан.** Үүнд Улиастай суманд үйл ажиллагаа эрхэлж буй Нийгмийн даатгалын хэлтэс, Баялаг супермаркет, Жим энтернишнл ХК-ний агуулах, Удвал бейкери, Playstatsion тоглоомын газар зэрэг 5 Аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм стандартын хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтыг зохион явууллаа.

**Гамшгаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын талаар** Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг зайлшгүй байх шаардлага норм, стандартын дагуу байрлуулаагүй, багаж хэрэгсэлд техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангаагүй, Гамшгаас хамгаалах болон гал унтраах шуурхай төлөвлөгөөгүй, гамшгаас хамгаалах эрсдэл, эмзэг байдлын үнэлгээ хийлгээгүй, ажилчдад гамшгаас хамгаалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, дадлага зохион байгуулаагүй, гал унтраагуулуудын цэнэг дууссан, аврах гарцын бүдүүвч, чиг заасан тэмдэг тэмдэглэгээ хийгээгүй, байгууллагын хэмжээнд галын аюулгүй байдлыг хангах заавар журам гарган баталж мөрдүүлэн ажиллаагүй, цахилгааны ерөнхий самбарын өрөөнд эд зүйлс хураасан зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн.

Мөн галын дохиоллын систем, гал унтраах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан авахад шаардагдах төсөв зардлыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөндөө тусгаагүй, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулаагүй, галын аюулгүйн шаардлагын дагуу барилга байгууламжийн мод, төмөр, хийц бүтээц, даавуу, хөшиг зэрэг шатамхай эд зүйлийг галд тэсвэртэй бодист түрхлэг, нэвчилгээ хийгээгүй зэрэг нийт 65 зөрчил илрүүлж газар дээр нь 13 зөрчлийг арилгуулж ажиллаа.

**Урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулж,** Цагаан сар нэгдсэн арга хэмжээний хүрээнд Улиастай сумын Жинст, Богдын гол, Өлзийт багуудын нутаг дэвсгэрт байрлах Модон хийц бүхий орон сууц, нийтийн байр бүхий

71 айл өрхийг хамруулан 31 зөрчил илрүүлснээс газар дээр нь 10 зөрчилийг арилгуулан 303 иргэнд галын аюулаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгсөн.

#### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

**4.1. Боловсрол, соёлын чиглэлээр:** Улиастай сумын хүүхдийн цэцэрлэгийг ариутгах халдваргүйжилтийн ажлыг аймгийн Зооноз судлалын төвтэй хамтран зохион байгуулж, 11 цэцэрлэг хамрагдлаа.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагын Завхан аймаг дахь салбартай хамтран зөвлөлдөх уулзалтыг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр аймгийн ЗДТГ-т зохион байгууллаа.

Уулзалтад 20 гаруй хүн оролцож, хүүхэд бүрийн хөгжил, төлөвшил, боловсролын төлөөх хамтын ажиллагааны үр өгөөжийг дээшлүүлэх талаар харилцан санал солилцлоо.

БСШУС-ын яамнаас ирүүлсэн “СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШИГЧДЭД БОЛОВСРОЛЫН БАРИМТ БИЧИГ ОЛГОХ ЖУРАМ”-ын төслийг Ерөнхий боловсролын 29 сургууль болон суурь, бүрэн дунд боловсрол олгодог мэргэжлийн сургуулиудын багш, удирдах ажилтнуудад хүргүүлж, тэдний саналыг боловсруулан нэгтгэж, БСШУС-ын яаманд хүргүүллээ.

Дэлхийн банкны хөнгөлттэй зээлийн санхүүжилтээр БСШУС-ын яамнаас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд нийлүүлсэн 213.6 сая төгрөгийн номыг аймгийн 29 Ерөнхий боловсролын сургуульд хүлээлгэн өглөө.

Боловсрол, соёл урлагийн салбарт хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг 2019 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан ажиллалаа.

Олон Улсын эмэгтэйчүүдийн баярын өдрийг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дунд “Ээжээ тандаа баярлалаа” шилдэг захидал болон гар зургийн уралдааны удирдамжийг боловсруулан хүргүүллээ.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын бага боловсрол, монгол хэлний боловсрол хариуцсан мэргэжилтнүүд Улиастай сумын хүүхдийн 1, 2 дугаар цэцэрлэгийн 50 гаруй багш ажилтанд 2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр “Зөв бичих дүрэм”-ийн сургалтыг зохион байгууллаа.

УИХ-ын гишүүн З.Нарантуяагийн санаачилгаар “НАРАНТУЯА” сангаас зохион байгуулсан “ЭРДМИЙН ГҮҮР” англи хэлний I шатны олимпиадыг 2019 оны 02 дугаар сарын 25-нд ЕБС-иуд сургууль дээрээ зохион байгуулж, 6-12 дугаар ангийн 6782 хүүхэд хамрагдлаа.

Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого аймагт 87,92 хувьтай явагдаж байна.

Сумдын соёлын төвүүдээс техник хэрэгсэл, хөгжмийн зэмсэгийн хэрэгцээний судалгаа авч, шаардлагатай байгаа техник хэрэгсэл, хөгжмийн зэмсэгийн захиалгыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлээ.

**4.2.Эрүүл мэнд, спортын чиглэлээр:** Аймгийн хэмжээнд 2019 оны 2 сарын 1-ний байдлаар 122 эх амаржиж, 120 хүүхэд амьд төрж, 32 хүн нас барж, нэг хүртэлх насны хүүхэд 2 эндэж, нийт 53 халдварт өвчин бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төрсөн эх 14(89.7%)-өөр буурч, нас баралт өнгөрсөн оны мөн үетэй адил түвшинд, халдварт өвчлөл 27(49%)-оор нэмэгдэж, халдварт бус өвчлөл 1071(120.7%)-ээр нэмэгдсэн байна. 1 сард 1.7 мянган өвчтөнийг 12.6 мянган ор хоногоор хэвтүүлж эмчлэн, 26.3 мянган хүнд амбулаториор үйлчилж, 121 жирэмсэн эхийг шинээр хяналтанд авсан байна.

Аймаг, сумдын эрүүл мэндийн байгууллагуудад 2019 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис ханган нийлүүлэх тендерийн сонгон шалгаруулалтыг Орон нутгийн өмчийн газарт зохион байгуулж, үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу 9 эм ханган нийлүүлэх ХХК-тай 263,0 сая төгрөгийн гэрээг хийж эм, эмнэлгийн хэрэгсэл урвалж бодисыг нийлүүлж эхэллээ.

Томуу, томуу төст өвчлөл, амьсгалын замын хүнд халдварын мэдээг Эрүүл мэндийн яаманд өдөр бүрийн 06:00-07:00 цагийн хооронд тогтмол мэдээлж менингококкын халдварын голомтын шуурхай арга хэмжээг авч ажиллалаа. Улиастай сумын ЕБ-ын сургууль, цэцэрлэгийн 12881 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Иргэдэд мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулж 87 албан байгууллагын 1321 албан хаагч, 2185 хүүхдэд хаагчдад “Менингококкт халдвараас сэргийлэх тухай” сургалтыг хийсэн байна. Орон нутгийн Шинэ –Завхан, air1 телевиз, FM –г 15 минутын сурталчилгааг 14 хоногийн турш цацсан байна. 02 дугаар сарын байдлаар томуу томуу төст өвчний эзлэх хувь 6.1 болж өмнөх 70 хоногоос 8.2 хувиар буурсан байна.

Сар шинийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор 2019 оны 02 дугаар сарын 04-ны өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 09-ны өдөр хүртэлх амралтын өдрүүдэд нийтийг хамарсан өвчлөл, хордлого, осол гэмтэл болон эмнэлгийн тусламж үйлчилгээний онцгой алдаа, зөрчлөөс сэргийлэх, таслан зогсоох, шуурхай арга хэмжээ авах үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг томилон ажиллууллаа. Амралтын өдрүүдэд түргэн тусламжийн нийт 497 дуудлага хүлээн авч үйлчилж, яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлсэн 180 хүн, яаралтай мэс засал 11 хийгдсэн ба нийт 20 эх эсэн мэнд амаржсан байна.



## НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Аймгийн хэмжээгээр нийгмийн даатгалын сангаас эхний 1 сард 11.1 мянган хүнд 3.6 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 1.4 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Эхний 1 сард 8321 хүн нийгмийн даатгалд хамрагдсаны 7500 буюу 90.1 хувь нь төсөвт байгууллага, ААНэгж байгууллагын даатгуулагч, 821 иргэн буюу 9.9 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна.

Сангуудаар авч үзвэл: тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 19.1 хувиар, ҮОМШӨ сангийн орлогын төлөвлөгөөг 41.6 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 25.1 хувиар тус тус давуулан биелүүлж, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 5.6 хувиар тасарсан байна.

Тэтгэвэрийн сангийн зарлага 3273.8 сая төгрөгт, Тэтгэмжийн сангийн зарлага 102.2 сая төгрөг, Эрүүл мэндийн сангийн зарлага 125.6 сая төгрөг, ҮОМШӨ-ний зарлага 51.4 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалийн сангаас 26.4 сая төгрөг тус тус зарцуулж нийт 3579.4 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, даатгалыг олгосон байна.

Халамжийн сангийн үйл ажиллагааны мэдээгээр Халамжийн тэтгэвэр 1757 хүнд 441.9 сая төгрөг, нөхцөлд мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт, тусламж 23514 хүнд 1462.8 сая төгрөг нийт 25271 хүнд 1904.7 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг орон нутгийн сан болон улсын төсвийн санхүүжилтээр үзүүлсэн байна.

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1039 болж, өнгөрсөн оны мөн үеэс 36.8 хувиар буюу 606 хүнээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 544 эмэгтэй ажил идэвхитэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 52.4 хувийг эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 14.5 хувь нь 15-24 нас, 33.2 хувь нь 25-34 нас, 28.1 хувь нь 35-44 нас, 19.6 хувь нь 45-54 нас, 3.9 хувь нь 55-59 нас, 0.7 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна.

Ажилгүйчүүдийн 1.6 хувь нь боловсролгүй, 3.5 хувь нь бага, 7.7 хувь нь суурь, 52.8 хувь нь бүрэн дунд, 5.7 хувь нь техникийн болон мэргэжлийн, 4.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 23.8 хувь нь дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж байна.

**Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:** 2019 оны 2-р сарын 1-ний байдлаар аймгийн дүнгээр 1.6 мянган том мал зүй бусаар хорогдоод байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 24.1 дахин буюу 37.0 мянган толгойгоор буурсан байна. Нийт хорогдолд хээлтэгчийн хорогдол 1.8 хувь, бог малын хорогдол 80.1 хувь, бод малын хорогдол 19.9 хувийг тус тус эзэлж байна.

Мал хамгаалах санд 2019 оны ноос,арьс, ширний урамшуулал олгоход шаардагдах хөрөнгө, ЭМААХДХ (Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр)-ийн хүрээнд шаардагдах тоног төхөөрөмжийн судалгааг нэгтгэн хүргүүлсэн.

Мөн мал хамгаалах санд Үндэсний үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай журмын дагуу урамшуулал олгох явцад малчин мал бүхий иргэдээс ирсэн санал гомдлыг, хүргүүллээ.

Хаврын тариалалтад шаардлагатай үрийн хэмжээг тариалах талбайгаар тооцон гаргаж үр тариа, малын тэжээл, төмс, хүнсний ногооны дутагдах үрийн захиалгыг гаргаж ХХААХҮЯамны ГТБХЗГазарт хүргүүлж байна. Энэ онд үр тариа 170 тн, малын тэжээлийн үр 131.3 тн, төмс 58 тн, төл сонгинын үр 3100 кг, хүнсний ногооны үр 166.9 кг дутагдаж байна.

Сум хөгжүүлэх сангийн 2018 оны жилийн эцсийн мэдээг 24 сумаас авч нэгтгэн гаргаж Жижиг дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүллээ. Уг мэдээгээр 2018 онд 306 аж ахуйн нэгж, иргэнд 1220.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож 277 ажлын байр шинээр бий болсон байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийг 2011 оноос хойш олгож эхэлсэн бөгөөд өссөн дүнгээр нийт 3182 аж ахуйн нэгж иргэнд 11742.052 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. Одоогийн байдлаар 1663 аж ахуйн нэгж, иргэний 4553.76 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

“Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээний II үе шатны үйл ажиллагааг 2019 оны 01-р сарын 24-ны өдөр аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгуулж, нийт 46 хүнс, хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагууд оролцож II шатны үйл ажиллагааны нээлтийг зохион байгуулан ажилласан. Мөн “Давс багатай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжье” арга хэмжээнд оролцох аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хийгдэж байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/97 тоот захирамжаар батлагдсан Стандарт хэмжил зүйн хэлтсийн дэргэдэх орон тооны бус баталгаажуулалтын зөвлөл нь 2019 оны 02-р сарын 21 –ний өдөр Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар 2019 онд хийх ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэн батлав. Мөн хурлаар 21 худалдааны газрын үнэлгээний дүнтэй танилцаж 17 хүнсний худалдаа үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээний хугацааг сунгах 2 хүнсний дэлгүүрт шинээр тохирлын гэрчилгээ олгох, 2 хүнсний дэлгүүрийн үл тохирлыг бүрэн залруулсны дараа дахин хэлэлцэхээр шийдвэр гаргалаа.

## Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

**6.1.Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** Аймгийн хэмжээнд кадастрын зургийн солбицолын нэгдсэн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор мод үржүүлгийн газрын талбай Улиастай, Алдархаан сумдын нутагт хоёр хуваагдан бичиг баримтын зөрчил үүссэн ба тухайн газруудад кадастрын зургийн хэмжилт хийлгэн гэрээ, гэрчилгээг шинэчлүүлэн улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Аялал жуулчлалын салбар дахь 3 үгт хаягжилтын хувьсал сэдэвт сургалтыг 2 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, сургалтанд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААН, байгууллагууд оролцлоо.

Байгууллагын гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг Онцгой байдлын газрын дарга Ө.Болд, БОАЖГазрын дарга Б. Мөнхбат нараар батлуулан ажиллалаа.

Байгаль орчин аялал жуулчлалын яам, Цэнгэг усны нөөц Байгаль хамгаалах төвөөс зохион байгуулж байгаа “Байгаль хамгаалах уламжлал” сэдэвт гар зургийн уралдаан, “Нэг удаагийн нийлэг хальсан уутнаас татгалзъя” видео уралдааны удирдамжийг Улиастай сумын Чандмань Эрдэнэ лаборатор сургууль, Жавхлант цогцолбор сургууль, Ерөнхий боловсролын 3,4-р 10жил, Дэвшил сургуулийн Эко клубууд болон 24 сумын Байгаль хамгаалагч нарт хүргүүлж мэдээлэл зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



**“Байгаль хамгаалах уламжлал” сэдэвт гар зургийн уралдаан**

2019 онд Булган, Орхон, Төв, Дундговь, аймгуудад Гахайн Африкийн мялзан өвчин гарч халдвар богино хугацаанд өргөн газар нутгийг хамрах өндөр эрсдэлтэй байгаатай холбогдуулан Завхан аймгийн 24 сумын байгаль хамгаалагчдад Гахайн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлсэн. Мөн Завхан аймгийн нэгдсэн групп, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын фэйж хуудас, аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй томоохон ресторан, худалдааны төвүүдэд 80 гаруй ширхэгийг тараан сурталчилж ажиллалаа.

**Халдварлах арга зам:**

- Өвчний амьтнаас эрүүл гахайд шууд хавьтлын замаар.
- Өвчний гахайг зориудаар нидэлсэн тохиолдолд гахайн мах, цус, шүүрээс, шүлс, тархир бусад хэрэгслээр эрүүл гахайд.
- Өвчин гарсан аж ахуй болон гахайтай ажилласан хүний хувцас, машины дугуй болон вирусгүй зөөвөрлөх болох бусад гадаргуугаар дамжин халдварлах.
- Богино зайд агаар дуслын замаар (битүү байранд) халдварладаг болно.
- Шавьж, шүүвү, мал, амьтан, нохой, мэрэгчид механикаар дамжуулна.

**Өвчний тухай ерөнхий ойлголт:**

Гахайн Африкийн мялзан өвчин нь Африк тивийн Иөн улсад анх 1927 онд бүртгэгдсэн бөгөөд одоогоор Европ, Ази, Африкийн 43 оронд халдварын тохиолдол бүртгэгддэг байна. Уг өвчөөр зөвхөн хэрэгсэл болон гарин тэжээвэр гахай өвчлөх бөгөөд хүн болон бусад амьтад халдварлаагүй. Өвчний вирус нь харьцангуй тэсвэртэй, бүтэн сарын хугацаанд хөлдөөсөн цус, тасалганы хэмд байгаа цусанд халдварлах чадвартайгаар хадгалалдаг. Мөн удаан хугацааны туршид халдварлуулах чадвар бүхий вирус нь гахайн түүхийн мах, махан бүтэцтэй байдаг. Одоогоор энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын вакцин, эмчлэх арга зүйг эцэслэн тодорхойлоогүй байна.

**Шинж тэмдэг:** Өвчний далай хэлбэр нь 3-15 хоногийн хугацаанд явагддаг. Харуу чанар өндөртэй вирусээр халдварласан тохиолдолд эрлэг болон гарин тэжээвэр гахайд өндөр халуурах (41-42.0С), тэжээлийн дуршилгүй болох, чихрийн ууцур, суул, цэж, хэвлий хэжлэх цус шүүрэх зэргэ шинж тэмдэг үзүүлж богино хугацаанд өлнөөр үхж хордоно.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 04 дүгээр сарын 20-ны



**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН  
2017 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДРИЙН А/97  
ДУГААР ТООТ ТУШААЛААР...**



өдрийн тушаалаар Ой хээрийн түймрийн идэвхтэй үе болох 3 дугаар сарын 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд жам ёсоор унасан бугын эврийг түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглосон. Үүнтэй холбоотойгоор сумдын байгаль хамгаалагч нарт мэдээлэл өгч олон нийтийн сүлжээнд тавьж сурталчилах

ажлыг зохион байгуулсан.

Завхан аймгийн Алдархаан сумын Богдын гол багийн Хөх ам гэх газарт Ирвэс айлийн мал идлээ гэх мэдээллийн дагуу 2019 оны 2 дугаар сарын 8-9-ны өдрүүдэд газар дээр нь очиж ажиллалаа. Тус аманд өвөлжиж буй 2 айлаас 2019 онд нийт 20 гаруй бог идсэн гэж малчид ярьж байлаа.

Snow Leopard- Цоохор ирвэс нь Улаан номонд орсон, Амьтны тухай хуулийн 7.1 дэх заалтаар нэн ховор амьтны жагсаалтанд орсон.

Цаашид тухайн амьтныг хамгаалахын тулд нөхөрлөл байгуулах, Ирвэснээс малаа хамгаалах хашаа барих, төсөл хөтөлбөрт хамруулах арга замууд байгааг иргэдэд ойлгуулж, хамгаалах арга замыг хайж байна.

**6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл эхний 1 сарын байдлаар оны үнээр 2 тэрбум 16.6 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 52.3 хувиар буюу 692.2 сая төгрөгөөр өссөн байна. Нийт үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 41.1 хувийг, хүнсний үйлдвэрлэл 6.6 хувь, хувцас үйлдвэрлэл 9.4 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.8 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 1.8 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.2 хувь, боловсруулсан мах үйлдвэрлэл 39.8 хувь, бусад үйлдвэрлэл 0.2 хувь, гурил үйлдвэрлэл 0.1 хувийг тус тус эзэлж байна.

**6.3. Дэд бүтцийн чиглэлээр:** 2019 онд аймгийн хэмжээнд 24 сумын өвөлжөө хаваржааны кадастрын зургийг хийж мэдээллийн системд оруулах ажлын хүрээнд Цагаанчулуут сумын 112 өвөлжөө хаваржааны кадастрын хэмжилтийг 2019 оны 02 сарын 21-ний өдрөөс 25 хооронд “Дядан” ХХК хийж гүйцэтгэлж, хүлээлгэн өглөө.

Инженерийн дэд бүтэц болох усан хангамж ариутгах татуурга, дулаан хангамж цахилгаан хангамж холбоо мэдээлэл, үерийн хамгаалалтын барилга байгууламжийн

өнөөгийн байдлын судалгааг хавсралт маягтын дагуу 24 сумаар гарган нэгтгэж гаргаж БХБЯ-нд хүргүүлсэн.

Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн барилга, Нөмрөг, Шилүүстэй сумын сургуулийн 75 хүүхдийн барилгын засвар, Баянтэс, Тэлмэн сумын ЭМТ-ийн барилгын засварын ажлуудын зураг , ажлын тоо хэмжээ, Баянхайрхан сумын 200 хүний суудалтай соёлын төвийн барилгын засвар, аймгийн уламжлалт анагаах ухааны төвийн барилга худалдан авах ажлын даалгаврыг тус тус гаргаж тендер зарлуулаад байна.

Аймгийн хэмжээний барилга байгууламжийг эрэмбэлэн 2020 онд шинээр баригдах болон засварлагдах барилгын судалгааг гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн.

Цагаанчулуут сумын төв төвлөрсөн халааттай холбогдож, хүсэлт ирүүлсний дагуу төсвийн байгууллагуудын барилгын эзэлхүүнийг норм аргачлалын дагуу гаргаж баталгаажуулан хүргүүлсэн.

2019 онд шинээр баригдах Багш, хөгжлийн ордоны барилга, Алдархаан сумын Эрүүл мэндийн төвийн барилга, Идэр, Нөмрөг, Түдэвтэй сумд баригдах 200 хүний суудалтай Соёлын төвийн барилга, Баянтэс сумд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгад “Инженер геодиз” ХХК-аар инженер геологийн судалгаа дүгнэлт гаргуулсан.

**ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**